

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
1	Тоног төхөөрөмжийн ангилалд хамаарах 13 харилцагчтай холбоотой 943.9 сая төгрөгийн ажил гүйлгээний НӨАТ-ыг хувь тэнцүүлэн хасагдах НӨАТ-аар бүртгээгүй	1	943.9	-	-	1	943.9	1	943.9	-	-	-	-
2	Үйл ажиллагааны орлогыг 171.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан	1	171.9	1	171.9	-	-	1	171.9	-	-	-	-
3	Санхүүгийн тайланд НДШ-ийн өглөгийг 8.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	8.9	-	-	1	8.9	1	8.9	-	-	-	-
4	Бараа материалын дансанд тоо хэмжээ 0 утгатай, үлдэгдэл өртөгтэй хөрөнгө болон 1 төгрөгөөр бүртгэсэн 105 нэр төрлийн 44.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	44.9	-	-	1	44.9	-	-	1	44.9	1	44.9
	Дүн	4	1,169.60	1	171.9	3	997.7	6	1,124.70	1	44.9	1	44.9

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д-д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ажилтнуудын ажилласан жилийн бүртгэл, судалгаа хангалтгүйгээс 6 ажилтанд ажилласан жилийн нэмэгдэл 4.0 сая төгрөгийг илүү олгосон байна.	1	4.0	1	4.0	-	-	-	-
2	Өмнөх аудитаар эд хөрөнгийн тооллогоор дутагдсан 443.6 сая төгрөгийн бараа материал, 2019-2022 онд хэрэгжсэн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд ашиглагдаж байсан 770.5 сая төгрөгийн хөрөнгө нийт 1,214.2 сая төгрөгийн хөрөнгө бодитоор байхгүй, дутагдал илэрснийг хуулийн байгууллагад шилжүүлэх албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.	1	1,214.2	-	-	1	1,214.2	-	-
3	Тайлант онд худалдаж аваад, зарцуулаагүй 63 нэр төрлийн 479.2 сая төгрөгийн бараа материалын нөөц нэмж үүсгэсэн, өмнөх аудитаар бараа материалын үлдэгдлийг тооцохгүйгээр тайлант оны хэрэгцээг үндэслэн төлөвлөдөг, чанарын шаардлага хангахгүй, бараа материал худалдан авсан, насжилт өндөртэй бараа материалын нөөц үүсгэсэн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	479.2	-	-	1	479.2	-	-
4	Шатахуун нийлүүлэх, МТЗ/20240102155 кодтой тендерийн багц-1-т 5.1 сая төгрөг, багц-2-т 11.3 сая төгрөгийн үнийн хөнгөлөлт үзүүлэх саналыг тендерт шалгарсан Сод Монгол групп ХХК-аас ирүүлсэн ба гэрээ байгуулахдаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй, тендерт ирүүлсэн үнийн санал 547.2 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Харьцуулалтын аргаар худалдан авах 52.9 сая төгрөгийн барааг нэр төрлөөр нь задалж шууд худалдан авалт хийсэн байна.	1	69.3	-	-	1	69.3	-	-
5	"Дүрэмт хувцас худалдан авах" 214.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт оролцогчдыг шалгаруулахдаа ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага хангаагүй Урбан жийнс ХХК-ийг сонгон шалгаруулсан нь гэрээний үүргээ биелүүлж чадахгүйд хүрч, Бөртэ ТӨҮГ-тай 151.8 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан.	1	151.8	-	-	1	151.8	-	-
6	УИХ, ЗГ-ын бодлого шийдвэрийг сурталчлах, таниулах, мэдээлэл өгөх зорилгоор зарцуулсан 28.0 сая төгрөгийн томилолтын зардал нь анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	1	28.0	-	-	-	-	1	28
7	Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 240 хүнд 10.2 сая төгрөгийн илүү, 10 хүнд 1.9 сая төгрөгийн дутуу хөнгөлөлт эдлүүлж, өглөг авлагад тусгаагүй байна.	1	12.1	-	-	-	-	1	12.1
8	Гэрээт ажлын хөлс 35.8 сая төгрөгийг 8 иргэнд олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл 8.2 сая төгрөгийг суутгаагүй, тайлагнаагүй байна.	1	8.2	-	-	-	-	1	8.2
	Дүн	8	1,966.8	1	4.0	4	1,914.5	3	48.3

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Үнэлгээний хорооны ажилтнууд тендерийг үнэлэхдээ Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/255 дугаар тушаалын хавсралт "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын дагуу холбогдох маягтуудыг хөтлөөгүй, ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг дутуу бөглөсөн зэрэг нийтлэг зөрчлүүд байна.	1	-	-	-	1	-
2	Оны эхэнд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2 удаа тодотгож 33,151.5 сая төгрөг буюу 55.6 хувиар нэмэгдүүлсэн мөн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан шинэ техник технологийг нэвтрүүлэх, төмөр замын машин механизмыг засварлах, хил дамнуулан зөөж тээвэрлэх зэрэг ажлууд урт хугацаанд, он дамжин хэрэгжиж байгааг дараа оны бизнес төлөвлөгөөнд тусгаагүй зэрэг зөрчил байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-